

DEVELOPMENTAL DISABILITIES ADMINISTRATION (DDA)
**Дөрвөн (4) Нас Хүрэхэд Хүчинтэй Хугацаа
Дуусах Тухай Мэдэгдэл**

ОГНОО:

ХАРИЛЦАГЧИЙН НЭР БА ХАЯГ

ТӨЛӨӨЛӨГЧИЙН НЭР БА ХАЯГ

ХАРИУ: ДӨРВӨН (4) НАС ХҮРЭХЭД ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА ДУУСАХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Таны хүүхэд одоогоор Developmental Disabilities Administration (DDA) -ын харилцагч мөн болно. Таны хүүхдийн DDA -ын харилцагч байх хугацаа түүний дөрвөн насны төрсөн өдрөөр дуусгавар болно. Хүүхдээ DDA -ын харилцагч хэвээр үлдээхийн тулд, та хүүхдээ дөрөв хүрэхээс өмнө дахин бүртгүүлэх шаардлагатай. Таны хүүхэд дараах өвчтэй тохиолдолд харилцагч хэвээр үлдэх болзлыг хангана: Оюуны Хомсдол, Тархины Саа, Уналт таталт, Аутизм, Оюуны Хомсдолтой төстэй Мэдрэлийн болон бусад Өвчнүүд.

Бид энэхүү дахин болзлыг хангахад юу хэрэгтэй талаар тусгасан Шаардлагатай Бичиг Баримтын Хүснэгтийг хавсаргалаа.

Би хэрхэн дахин бүртгүүлэх вэ?

Дахин бүртгүүлэх хүсэлт гаргахын тулд хүүхдийнхээ дөрвөн насны төрсөн өдрөөс дор хаяж 90 хоногийн өмнө DDA Intake & Eligibility ажилтантай холбогдоно уу. Та доор жагсаасан утасны дугаарт залгах эсвэл бичих замаар хүсэлтийг гаргаж болно. Өргөдлийн багцыг танд шуудангаар илгээнэ. Та өргөдлийн бичиг баримтыг <https://www.dshs.wa.gov/dda/consumers-and-families/eligibility> хаягаар зочлох замаар онлайнаар авах боломжтой.

Хэрэв би дахин бүртгүүлэх хүсэлт гаргахгүй бол яах вэ?

Хэрэв та дахин бүртгүүлэх хүсэлт гаргахгүй эсвэл хүүхдийнхээ төрсөн огнооноос дор хаяж 60 хоногийн өмнө өргөдлийг гаргахгүй бол, хүүхдийн тань DDA -ын харилцагчийн эрх түүний дөрвөн насны төрсөн өдрөөр дуусгавар болно. Хэрэв таны хүүхэд DDA -ээс төлбөртэй үйлчилгээ авдаг бол, уг үйлчилгээ нь түүний дөрвөн насны төрсөн өдрөөр дуусна.

DDA -ын харилцагч хэвээр үлдэх хугацаа дуусгавар болох нь Special Education хөтөлбөрүүд эсвэл SSI -ын болзлыг хангахад оролцоход нөлөөлөхгүй. Мөн энэ нь таны хүлээн авч буй Medicaid, TANF эсвэл хүнсний ваучер зэрэг DSHS үйлчилгээнүүдэд нөлөөлөхгүй.

Аль болох хурдан, хүүхдийнхээ дөрвөн насны төрсөн өдрөөс дор хаяж 90 хоногийн өмнө хариу өгнө үү. Хэрэв таниас хариу ирэхгүй бол, бид таныг хүүхдээ DDA-ын харилцагч хэвээр үлдээхийг хүсэхгүй байна гэж ойлгох болно. Дөрвөн (4) нас хүрэхэд болзол хангахыг батласан тохирох бичиг баримтыг өгөөгүй тохиолдолд, таны хүүхдийн DDA -ын харилцагч хэвээр үлдэх болон DDA үйлчилгээнүүд түүний (4^{насны}) төрсөн өдрөөр дуусгавар болно.

Хэрэв танд асуулт байгаа эсвэл өргөдлийн багц бичиг баримт авахыг хүсвэл, дараахаар холбогдоно уу

НЭР

УТАСНЫ ДУГААР

Э-МЭЙЛ ХАЯГ

Болзол хангах талаарх мужийн дүрмийн хуулбарыг хүсэлт гаргаснаар авч болох ба эсвэл <https://www.dshs.wa.gov/dda/consumers-and-families/eligibility> дээрээс онлайнаар харах боломжтой.

сс: Харилцагчийн файл

Шаардлагатай Бичиг Баримтын Хүснэгт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ	НАС	ОНОШ	ОНОШ ЗҮЙЧ	БУСАД БҮРТГЭЛҮҮД
Хөгжлийн Хоцрогдол	4-9 Нас хүртэл	Хөгжлийн Хоцрогдол	Хөгжлийн үнэлгээ эсвэл үнэлэмжийг удирдах мэргэшсэн мэргэжилтэн	Дөрвөн (4) наснаас есөн (9) нас хүртэл – дундажаас доогуурх гурав ба түүнээс олон 1.5 стандарт хазайлтууд эсвэл өнгөрсөн 12 сарын доторх үнэлгээн дээр тулгуурласан он дарааллын насны 25 %.
Оюуны Хомсдол	4 нас ба түүнээс дээш	Оюуны Хомсдол	Washington Certified School Psychologist -ийн Licensed Psychologist, эсвэл National Assoc. of School Psychologists -ээс итгэмжлэгдсэн бусад сургуулийн сэтгэл зүйч	Дундажаас доогуурх хоёроос дээш стандарт хазайлтын Бүрэн Хэмжүүрт IQ оноо болон сүүлийн 36 сарын дотор гүйцэтгэсэн дундажаас доогуурх хоёроос дээш стандарт хазайлтын дасан зохицох чадварын тестийн оноог багтаасан Бүрэн Хэмжээний Сэтгэл Зүйн Тайлан.
Тархины Саа	4 нас ба түүнээс дээш	Тархины Саа Дөрвөн Мөчний Саа Хагас Саажилт Бүтэн Саажилт	Licensed Physician	Гурван (3) наснаас өмнө эхлэсэн бөгөөд хоёр эсвэл түүнээс олон үйл хөдлөлүүдэд (бие засах, усанд орох, идэх, хувцаслах, хөдлөх эсвэл харилцах) өдөр тутмын шууд биет тусламж шаардлагатайг нотлосон мэдээлэл.
Уналт таталт	4 нас ба түүнээс дээш	Уналт таталт эсвэл Саажилтын Эмгэг	Board Certified Neurologist	Өвчний түүх ба мэдрэлийн үзлэгт тулгуурласан онош, хянах боломжгүй болон үргэлжилсэн эсвэл үе үе сэдэрдэг саажилтыг эмч эсвэл мэдрэлийн эмчээр баталгаажуулсан баталгаажуулалт, дундажаас доогуурх хоёроос дээш стандарт хазайлтын дасан зохицох үйл ажиллагаан дахь үлэмж хэмжээний хязгаарлалтыг харуулсан дасан зохицох чадварын тест.
Аутизм (DSM-IV-TR нэг бүрээр)	4 нас ба түүнээс дээш	Аутизм эсвэл Аутизмын Эмгэг DSM-IV-TR дэх 299.00 нэг бүрээр	Аутизмын төв, хөгжлийн төв эсвэл эрүүл мэндийн сайн сайхны төвтэй холбоотой ажилладаг Licensed Psychologist, Licensed Physician, ARNP эсвэл Магадлан Итгэмжлэгдсэн: Neurologist, Psychiatrist, эсвэл Developmental and Behavioral Pediatrician	Бүх шалгуурыг хангаж буйг харуулсан DSM-IV-TR нэг бүрээрх бүрэн хэмжээний үнэлгээ, гурван (3) наснаас өмнө нийгмийн, хэл ярианы, харилцааны чадвар эсвэл бэлэг тэмдгийн эсвэл төсөөллийн тоглоомд хоцрогдолтой эсвэл хэвийн бус ажиллагаатайг харуулсан нотолгоо, дундажаас доогуурх хоёроос дээш стандарт хазайлтын дасан зохицох үйл ажиллагаан дахь үлэмж хэмжээний хязгаарлалтыг харуулсан дасан зохицох чадварын тест.
Аутизмын Хүрээний Эмгэг (DSM-5 нэг бүрээр)	4 нас ба түүнээс дээш	Аутизмын Хүрээний Эмгэг 299.00 Хоёр багана бүрт 2 эсвэл 3-р ноцтой байдлын түвшинг багтаасан DSM-5	Аутизмын төв, хөгжлийн төв эсвэл эрүүл мэндийн сайн сайхны төвтэй холбоотой ажилладаг Licensed Psychologist, Licensed Physician, ARNP эсвэл Магадлан Итгэмжлэгдсэн: Neurologist, Psychiatrist, эсвэл Developmental and Behavioral Pediatrician	Бүх шалгуурыг хангаж буйг харуулсан DSM-V нэг бүрээрх бүрэн хэмжээний үнэлгээ, гурван (3) наснаас өмнө ноцтой байдлын түвшний хэмжүүрийн хоёр багана дээр ноцтой байдлын хоёр эсвэл гуравдугаар түвшин бүхий хоцрогдолтой эсвэл хэвийн бус ажиллагаатайг харуулсан нотолгоо, дундажаас доогуурх хоёроос дээш стандарт хазайлтын дасан зохицох үйл ажиллагаан дахь үлэмж хэмжээний хязгаарлалтыг харуулсан дасан зохицох чадварын тест болон нэг болон дундажаас доогуурх стандарт хазайлтын FSIQ - эсвэл DSM-IV нэг бүрээрх Аутизмын Эмгэг 299.00 -ын бүх шалгуурыг хангаж буйг харуулах.

Шаардлагатай Бичиг Баримтын Хүснэгт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ	НАС	ОНОШ	ОНОШ ЗҮЙЧ	БУСАД БҮРТГЭЛҮҮД
Оюун Ухааны Хомсдолтой төстэй Өөр Мэдрэлийн эсвэл Бусад Эмгэгүүд	4 нас ба түүнээс дээш	Оюун ухааны болон дасан зохицох чадварын согог үүсгэдэг мэдрэлийн эсвэл хромсомын эмгэг	Licensed Physician	Дундажаас доогуурх 1.5-иас дээш стандарт хазайлтын Бүрэн Хэмжүүрт IQ оноо болон сүүлийн 36 сарын дотор гүйцэтгэсэн дундажаас доогуурх хоёроос дээш стандарт хазайлтын дасан зохицох үйл ажиллагаан дахь үлэмж хэмжээний хязгаарлалтыг харуулсан дасан зохицох чадварын тест.
Жич: Энэхүү маягт нь зөвхөн ерөнхий зааварчилгаа бөгөөд DDA нь нэмэлт мэдээлэл эсвэл үнэлгээ шаардаж болно. Энэхүү бичиг баримт бүрдүүлэлт нь болзол хангаж буй эсэхийг тодорхойлох анхны алхам юм. DDA болзол хангаж буй эсэхийг WAC 388-823 Бүлэг нэг бүрээр тодорхойлсон.				